



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нийцлийн аудитын тайлан

**АЙМГИЙН ИТХ-ЫН ТОГТООЛ, ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ,
ШИЙДВЭРИЙН ҮНДЭСЛЭЛ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ**



**АЙМГИЙН ИТХ-ЫН ТОГТООЛ, ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН
ТӨЛӨВЛӨЛТ, БОЛОВСРУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ
ХАНГАЛТГҮЙН УЛМААС ИЛТ ХУУЛЬ БУС ГЭЖ ҮЗЭХ ҮНДЭСЛЭЛТЭЙ
ЗАХИРГААНЫ АКТУУД БАТЛАГДСАН БАЙНА.**

2020 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитын менежер Г.Наранбаяр Аудитор Б.Дарханбат М.Ундармаа 2020 оны 10 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543151 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 дугаар давхар, 209 тоот	Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Бүлэг-1 Хууль эрх зүйн үйлчлэл үзүүлэхгүй байх үр дагавартай захиргааны актуудыг батлан гаргасан байна. 6 1.1. Эрх зүйн актын үндэслэл болон агуулга хууль тогтоомжид бүрэн нийцэж чадаагүй байна. 6 1.1.1. АИТХ, Тэргүүлэгчдийн хууль тогтоомжид нийцээгүй тогтоолын тоо 2019 онд өмнөх оноос 18 хувиар нэмэгдсэн байна. 6 1.1.2 Аймгийн ЗД-ын захирамжийн үндэслэлийн 3.8-4.9 хувь нь холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудтай бүрэн нийцээгүй байна. 7 1.1.3. АИТХ-ын тогтоолын агуулга нь үндэслэл болгосон хууль тогтоомжтойгоо нийцсэн бол аймгийн Засаг даргын захирамжийн агуулгын 1.4%-3.4% нь үндэслэл болгосон хууль тогтоомжтойгоо бүрэн нийцээгүй байна. 8 Бүлэг-2 Эрх зүйн актуудын хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй, дүн шинжилгээ хийж эрх бүхий албан тушаалтанд тайлагнаагүйгээс жил бүр хууль эрхзүйн зөрчилтэй тогтоол, 10 захирамж батлагдан гарсаар байна. 10 2.1 Аймгийн ИТХ-ын тогтоол, ЗД-ын захирамжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна. 10 2.1.1 Аймгийн ИТХ-ын тогтоолын биелэлтэд тавих хяналт хангалтгүй, хэрэгжилтийг тухай бүр тооцож ажиллаагүй байна. 10 2.1.2 Аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтэд тавих хяналт хангалтгүй, хэрэгжилтийг тухай бүр холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнаагүй байна. 11 2.1.3 Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамжийн биелэлтийн тайланг нэгтгэн гаргаж, дүн шинжилгээ хийж эрх бүхий этгээдэд тайлагнаагүй байна. 13 2.1.4 Хэлтсүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулснаар дотоод хяналт үр дүнтэй хэрэгжих боломжтой байна. 13 ДҮГНЭЛТ 14 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ 14 ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ: 14 ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР: 14 ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР: 14
---	---

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 5 дугаар тогтоол, “Аудитын төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны “Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” А/53 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд нийцлийн аудитыг хийлээ.

2. Аудитын зорилт:

Аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжийн хууль эрх зүйн үндэслэл, хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад 2017-2019 он, 2020 оны эхний хагас жилд батлагдан гарсан аймгийн ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамжийг хамруулан холбогдох мэдээ, баримт материал, судалгаанд тулгуурлан аудитыг хийж гүйцэтгэлээ.

4. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, тулган баталгаажуулах зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ, аудитын судалгаа хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, аудитор Б.Дарханбат, М.Ундармаа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Хүндрэл бэрхшээл

Аймгийн ИТХ, Засаг даргын шийдвэрийн биелэлтийг тухай бүр нэгтгэн гаргаж тайлагнаагүйн улмаас тэдгээрийн биелэлтийн тайланг аудитын явцад нөхөн гаргуулж авсан нь аудитын тайлан хөтөлбөрийн дагуу хугацаандаа бичигдэхэд сөргөөр нөлөөлж төлөвлөсөн хугацаанаас хожимдсон болно.

8. Үндсэн мэдээлэл

Аймгийн ИТХ нь 2017 оны 01 сарын 01-ний өдрөөс 2020 оны 06 сарын 30-ны хооронд 10 удаа хуралдаж 61 тогтоол, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 102 удаа хуралдаж 169 тогтоол гаргажээ.

Тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг төлөвлөлтийн шатанд ирүүлээгүй бөгөөд аудитын явцад нөхөн гаргуулж биелэлтийг хувийг тооцсон болно.

Аймгийн Засаг дарга нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд 2017 оны 01 сарын 01-ний өдрөөс 2020 оны 06 сарын 30-ны хооронд нийт 1595 захирамж гаргасан бөгөөд захирамжийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 2017 онд 98.7%, 2018 онд 98.2%-тай дүгнэсэн бөгөөд Хууль, эрх зүйн хэлтсээс 2019 оны хэрэгжилтийг нэгтгэж Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлээгүйн улмаас хяналт хийгдээгүй. 2020 оны эхний хагас жилийн байдлаар хяналт хийгдээгүй байсныг аудитын явцад нэгтгүүлэн авч тайланд тусгалаа.

Бүлэг 1

Хууль эрх зүйн үйлчлэл үзүүлэхгүй байх үр дагавартай
захиргааны актуудыг батлан гаргасан байна.

1.1. Эрх зүйн актын үндэслэл болон агуулга хууль тогтоомжид бүрэн нийцэж чадаагүй байна.

1.1.1. АИТХ, Тэргүүлэгчдийн хууль тогтоомжид нийцээгүй тогтоолын тоо 2019 онд өмнөх оноос 18 хувиар нэмэгдсэн байна.

Аймгийн ИТХ болон Тэргүүлэгчид нь хуульд заасан чиг үүргийн дагуу 2017 онд 79, 2018 онд 69, 2019 онд 71, 2020 оны эхний хагас жилийн байдлаар 50 тогтоол батлан гаргажээ.

Үүнээс 2017 оны 22-р тогтоол захиргааны хэм хэмжээг тогтоох шинжтэй байгаа боловч Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, захиргааны хэм, хэмжээний актын эмхэтгэлд нийтлүүлээгүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №1-т харуулав./

Иймд батлагдсан журмууд нь хуулийн шаардлагыг хангаагүй тул эрх зүйн үйлчлэл үзүүлэхгүй байх үр дагавартай бөгөөд захиргааны хэм хэмжээ тогтоож байгаа тогтоолуудыг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу бүртгүүлж, захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд хэвлүүлж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

“Аудитаар АИТХ-ын Тэргүүлэгч болон АИТХ-ын тогтоолын үндэслэлүүд нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжтой нийцэж буй эсэхийг шалгахад 2020 оны эхний хагас жилд батлагдсан 50 тогтоолын үндэслэл хуульд нийцэж байсан ба 2017 оны 79 тогтоолын 1 буюу 1.3 хувь, 2018 оны 69 тогтоолын 1 буюу 1.4 хувь, 2019 оны 71 тогтоолын 8 буюу 11.2 хувь нь эрхзүйн хангалттай үндэслэлгүй буюу хуульд бүрэн нийцээгүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №2-т харуулав./


Үүнд дараах хүчин зүйл нөлөөлжээ.

1. Тогтоолын төслийг шаардлага хангасан хэмжээнд боловсруулдаггүй
2. Аймгийн ИТХ-ын тогтоолын төслийг танилцах хуудастай хамт ажлын албаны дарга болон мэргэжилтнүүдэд танилцуулж санал авдаг боловч тэдгээрийн тавьж буй хяналт хангалтгүй

Дээрх шалтгааны улмаас хууль тогтоомжид нийцээгүй тогтоолын тоо 2019 онд өмнөх онуудаас нэмэгдсэн байна.

Хууль тогтоомжид нийцээгүй тогтоолын өсөлт, бууралтыг графикаар харуулбал:

/Дүрслэл 1/



Дүрслэлээс харахад хууль тогтоомжид нийцээгүй эрх зүйн актын тоо 2019 онд 13 болж нэмэгдсэн байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлд заасан захиргааны акт илт хууль бус болох үндэслэлтэй тул цаашид тогтоолын төлөвлөлт, боловсруулалтад тавих хяналтыг сайжруулах, хуульд нийцсэн захиргааны акт гаргах зөвлөмжийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.1.2 Аймгийн ЗД-ын захирамжийн үндэслэлийн 3.8-4.9 хувь нь холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудтай бүрэн нийцээгүй байна.

Аймгийн Засаг дарга нь өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд 2017 онд 436, 2018 онд 482, 2019 онд 473, 2020 оны эхний хагас жилд 204 захирамж батлан гаргасан байна.

Аймгийн Засаг даргын захирамжуудын хүчин төгөлдөр эсэхийг шалгах явцад дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

1. 2017 онд 1, 2018 онд 6, 2019 онд 8, 2020 оны эхний хагас жилийн байдлаар 1, нийт 16 захирамжийг дугаар алгасаж гаргасан, мөн 2018 оны А/373, А/418 тоот захирамжуудыг гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй бөгөөд архивын баримтад үдэж архивласан байна. Энэ нь тухайн захирамж батлагдан гарахаас өмнө захирамжийн дугаарыг урьдчилан олгодог, архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнууд тогтвор суурьшилтай ажилладаггүй байдал нөлөөлжээ.

Дээрх зөрчил нь Архивын Ерөнхий газрын даргын 2009 оны 07 сарын 07-ны өдрийн 68 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар"-ын 2 дугаар зүйлийн 2.3.12, 3 дугаар зүйлийн 3.5.7, 3.5.11 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2. Аймгийн Засаг даргын захирамжаар 2017 онд А/11, 2020 онд 1, нийт 2 захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг батлан гаргасан бөгөөд 2017 оны А/11-р захирамжаар батлагдсан журмыг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтлүүлээгүйгээс дээрх захиргааны актууд нь хууль эрх зүйн үйлчлэл үзүүлэхгүй байх үр дагавартай байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №1-т харуулав./

Иймд дээрх алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөх, захиргааны хэм хэмжээ тогтоож байгаа актуудыг хуульд заасны дагуу бүртгүүлэх, захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд хэвлүүлж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Аймгийн Засаг даргын захирамжийн үндэслэл нь хууль тогтоомж, эрх зүйн актад үндэслэсэн эсэхийг шалгахад 2017 оны 436 захирамжийн 18 буюу 4.1 хувь, 2018 оны 482 захирамжийн 24 буюу 4.9 хувь, 2019 оны 473 захирамжийн 18 буюу 3.8 хувь, 2020 оны 204 захирамжийн 13 буюу 6.4 хувь нь хууль эрх зүйн үндэслэл дутуу, хууль журмын заалтыг үнэн зөв хэрэглээгүй, хүчингүй буюу хамааралгүй заалтаар батлан гаргасан байна.

/Дэлгэрэнгүйг хавсралт №3-т харуулав./

Аймгийн Засаг даргын 2017-2019 он, 2020 оны эхний хагас жилийн хугацаанд гарсан зөрчилтэй захирамж, түүний эзлэх хувийг тоогоор илэрхийлэн хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 1/

Он	2017	2018	2019	2020
Нийт захирамжийн тоо	436	482	473	204
Үүнээс: Зөрчилтэй захирамжийн тоо	18	24	18	10
Нийт захирамжид эзлэх хувь	4.1%	4.9%	3.8%	4.9%

Хүснэгтээс харахад хуульд нийцээгүй захиргааны акт нийт захирамжийн 3.8-4.9%-ийг эзэлж байна. Үүнд: Засаг даргын захирамжийн зөвшөөрлийг авч түүнийг төлөвлөн боловсруулсан болон төслийг хянаж буй албан тушаалтнуудын хайнга байдал, ажлын хариуцлага нөлөөлжээ.

Дээрх захиргааны актууд нь Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлд заасан илт хууль бус гэж үзэх үндэслэлийг агуулж байгаа тул аймгийн Засаг даргын захирамжийн үндэслэл нь хууль тогтоомжтой бүрэн нийцэж чадаагүй байна.

Иймд захирамжийн төлөвлөлт, боловсруулалтад тавих хяналтыг сайжруулах, хуульд бүрэн нийцсэн захиргааны акт гаргах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.1.3. АИТХ-ын тогтоолын агуулга нь үндэслэл болгосон хууль тогтоомжтойгоо нийцсэн бол аймгийн Засаг даргын захирамжийн агуулгын 1.4%-3.4% нь үндэслэл болгосон хууль тогтоомжтойгоо бүрэн нийцээгүй байна.

Аудитаар аймгийн ИТХ-ын тогтоол болон Засаг даргын захирамжийн агуулгыг авч үзэхэд тогтоолын хувьд шагнал урамшуулал, хөтөлбөр төлөвлөгөө батлах, үндсэн хөрөнгөтэй холбоотой, хуралдааны тов тогтоох тухай тогтоолууд нь 50 орчим хувь, захирамжийн хувьд газрын харилцаатай холбоотой, ажлын хэсэг байгуулах, үнэлгээний хороо байгуулах, тусгай зөвшөөрөл олгох захирамжууд 50 гаруй хувийг эзэлж байна.

Тогтоолуудыг утга, агуулгаар нь ангилж хүснэгтээр харуулбал:

№	Утга агуулга	2017		2018		2019		/Хүснэгт2/ 2020	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Шагнаж урамшуулах	11	13.9%	12	17.4%	17	23.6%	2	4.0%
2	Хөтөлбөр, төлөвлөгөө батлах	5	6.3%	4	5.8%	4	5.6%	19	38.0%
3	Үндсэн хөрөнгө, түүнийг бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, худалдах, барьцаалах	14	17.7%	13	18.8%	8	11.1%	0	0.0%
4	Хуралдааны тов тогтоох, асуудал батлах	10	12.7%	11	15.9%	9	12.5%	0	0.0%
5	Бусад	13	16.5%	12	17.4%		0.0%	7	14.0%
6	Ажлын хэсэг, зөвлөл байгуулах	9	11.4%	10	14.5%	7	9.7%		0.0%
7	Төсөв, Бүтэц орон тоо батлах, өөрчлөх	5	6.3%	3	4.3%	3	4.2%	4	8.0%
8	Тогтоол хүчингүй болгох	1	1.3%	0	0.0%	11	15.3%	3	6.0%
9	Хөрөнгө зарцуулах	3	3.8%	1	1.4%	6	8.3%	0	0.0%
10	Аялал жуулчлал	0	0.0%	0	0.0%	0	0.0%	9	18.0%
11	Тэмцээн уралдаан	0	0.0%	2	2.9%	3	4.2%	4	8.0%
12	Журам батлах	3	3.8%	1	1.4%	2	2.8%	2	4.0%
13	Үйл ажиллагааг сайжруулах	4	5.1%	0	0.0%	2	2.8%	0	0.0%
14	Сонгуулийн үйл ажиллагаа	1	1.3%	0	0.0%	0	0.0%	0	0.0%
Нийт дүн		79	100.0%	69	100.0%	72	100.0%	50	100.0%

Хүснэгтээс харахад: 2017-2019 он, 2020 оны эхний хагас жилд батлагдан гарсан нийт тогтоолыг дунджаар авч үзвэл 16% нь шагнал урамшуулал, 12% нь хөтөлбөр төлөвлөгөө батлах, 13% нь үндсэн хөрөнгөтэй холбоотой, 11% нь хуралдааны тов тогтоох, 12% нь бусад /эрх шилжүүлэх, баяр ёслол, тогтоол хүчингүй болгох/, 10% нь ажлын хэсэг, 6% нь төсөв бүтэц орон тоо батлах, өөрчлөх, 6% нь тогтоол хүчингүй болгох, 4% нь хөрөнгө зарцуулах, 3% нь аялал жуулчлал, 3% нь тэмцээн уралдаан, 3% нь журам батлах, 2% нь үйл ажиллагаа сайжруулах, 0.4% нь сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой тогтоолууд эзэлж байна.

Захирамжуудыг утга, агуулгаар нь ангилж хүснэгтээр харуулбал:


№	Захирамжийн утга	2017		2018		2019		2020	
		Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь
1	Газар	71	16.32%	91	18.88%	95	20.00%	39	19%
2	Ажлын хэсэг	0	0.00%	2	0.41%	52	11.00%	23	11%
3	Үнэлгээний хороо	6	1.38%	5	1.04%	74	16.00%	29	14%
4	Тусгай зөвшөөрөл	66	15.17%	78	16.18%	36	8.00%	2	1%
5	Бусад	6	1.38%	8	1.66%	37	8.00%	20	10%
6	Шагнал урамшуулал	1	0.23%	3	0.62%	35	7.00%	9	4%
7	Хөтөлбөр төсвийн задаргаа	25	5.75%	29	6.02%	17	4.00%	19	9%
8	Хөрөнгө зарцуулах	41	9.43%	56	11.62%	16	3.00%	15	7%
9	Төсөв санхүү	23	5.29%	17	3.53%	14	3.00%	6	3%
10	Тусламж дэмжлэг	40	9.20%	41	8.51%	27	6.00%	5	2%
11	Цалин тогтоох, нэмэгдэл олгох	32	7.36%	16	3.32%	9	2.00%	9	4%
12	Гамшиг эрсдэл	22	5.06%	28	5.81%	13	3.00%	26	13%
13	Цол олгох	29	6.67%	16	3.32%	7	1.00%		0%
14	Сахилгын шийтгэл	8	1.84%	10	2.07%	8	2.00%		0%

15	Аян	30	6.90%	21	4.36%	18	4.00%		0%
16	Баяр ёслол	3	0.69%	3	0.62%	7	1.00%	2	1%
17	Тэмцээн уралдаан	6	1.38%	7	1.45%	6	1.00%		0%
18	Эрх олгох	27	6.21%	51	10.58%	2	0.00%		0%
Нийт дүн		436	100%	482	100%	473	100%	204	100%

Хүснэгтээс харахад: 2017-2019 он, 2020 оны эхний хагас жилд гарсан захирамжийн агуулгыг дунджаар 17% нь газрын харилцаа, 15% нь ажлын хэсэг байгуулах, 12% нь үнэлгээний хороо байгуулах, 8% нь тусгай зөвшөөрөл, 8% нь бусад /тангараг өргүүлэх, үзэсгэлэн худалдаа, гэрээ байгуулах, худгийн байршил тогтоох, цагийн хуваарь өөрчлөх, ээлжийн амралт олгох/, 6% нь шагнал урамшуулал, 5% нь хөтөлбөр төсвийн задаргаа, 5% нь хөрөнгө зарцуулах, 5% нь төсөв санхүү, 5% нь тусламж дэмжлэг, 4% нь цалин, 3% нь гамшиг эрсдэл, 2% нь баяр наадмын цол олгох, 1% нь сахилгын шийтгэл, 1% нь аян, 1% нь баяр ёслол, 1% нь тэмцээн уралдаан, 1% нь эрх олгохтой холбоотой гарсан захирамжууд эзэлж байна.


АИТХ-ын болон Засаг даргын захирамжуудыг гол 4 салбарт ангилж үзэхэд дийлэнх нь нийгмийн салбарт чиглэсэн байна.

АИТХ-ын тогтоолыг салбараар ангилж харуулбал:



Дүрслэлээс харахад: 2017 онд 51, 2018 онд 46, 2019 онд 47 буюу нийт тогтоолын 64.5%-71.8% нь нийгмийн салбарт чиглэсэн байна. Энэ нь аймгийн ИТХ-ын тогтоол нь нийгмийн салбарт илүү чиглэгдэж байгааг харуулж байна.

Аймгийн Засаг даргын захирамжийг салбараар нь ангилж харуулбал:



Дүрслэлээс харахад: 2017 онд 260, 2018 онд 303, 2019 онд 241 буюу нийт захирамжийн 50.9%-62.8% нь нийгмийн салбарт чиглэсэн байна. Энэ нь аймгийн Засаг даргын захирамж нь нийгмийн салбарт илүү чиглэгдэж байгааг харуулж байна.

Аймгийн ИТХ болон Тэргүүлэгчдийн тогтоолын хувьд агуулга нь үндэслэл болгосон хууль тогтоомжтойгоо бүрэн нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын 2017-2019 он, 2020 оны эхний хагас жилийн байдлаар батлан гаргасан захирамжийн агуулга үндэслэл болгосон хууль тогтоомжтойгоо бүрэн нийцэж чадаагүй байна. Тухайлбал: 2017 онд 15, 2018 онд 14, 2019 онд 15, 2020 онд 3 захирамж, нийт 47 захирамж /Дэлгэрэнгүйг хавсралт №4-д харуулав./

Нийтлэг илэрсэн зөрчлүүдийг авч үзвэл тухайн эрх зүйн актын агуулгад хамааралгүй заалт үндэслэл болгох, хамааралтай заалтыг авч хэрэглээгүй зэрэг алдаа түгээмэл байна.

Эдгээр зөрчлүүд нь захиргааны актыг илт хууль бус гэж үзэх үндэслэл болох тул цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

Баталсан эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх

Бүлэг 2

Эрх зүйн актуудын хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй, дүн шинжилгээ хийж эрх бүхий албан тушаалтанд тайлагнаагүйгээс жил бүр хууль эрхзүйн зөрчилтэй тогтоол, захирамж батлагдан гарсаар байна.

2.1 Аймгийн ИТХ-ын тогтоол, ЗД-ын захирамжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2.1.1 Аймгийн ИТХ-ын тогтоолын биелэлтэд тавих хяналт хангалтгүй, хэрэгжилтийг тухай бүр тооцож ажиллаагүй байна.

Аймгийн ИТХ нь 2017-2019 он, 2020 оны эхний хагас жилийн байдлаарх нийт 269 тогтоолын хэрэгжилтийг тухай бүр тооцоогүй байсан ба хэрэгжилтийг аудитын явцад нөхөн гаргууллаа.

Аймгийн Засаг даргад үүрэг чиглэл өгсөн тогтоолын биелэлтийг аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс улирал бүр хэрэгжилтийг гаргуулан авдаг бол Засаг даргаас бусад албан тушаалтанд үүрэг болгосон тогтоолын биелэлтийг тогтоосон хугацаанд тухай бүр гаргуулж аваагүй, хэрэгжилтийг тооцоогүй, хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5, 22.1.9 дэх заалтуудад аймгийн ИТХ-д гаргасан шийдвэр болон хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах эрхийг олгосон байдаг бөгөөд тогтоолын хэрэгжилтийг тухай бүр нэгтгэн гаргахгүй байгаа нь дээрх бүрэн эрхээ үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллаж чадахгүйд хүргэж байна.

Иймд аймгийн ИТХ-ын дарга болон ажлын алба нь дээрх хуулийн заалтуудыг хэрэгжүүлж тогтоосон хугацаанд тогтоолын биелэлтийг хангуулах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

Аймгийн ИТХ-ын ажлаас албанаас гаргаж ирүүлсэн тогтоолын хэрэгжилтийг он тус бүрээр хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 4/

Хэрэгжилт	2017	2018	2019	2020 оны эхний хагас жил	Дүн
100%	70	55	54	30	209
70%	1	1		7	9
30%	1	1	2	2	6
0%					0

Хугацаа болоогүй	7	12	15	11	45
Нийт тогтоолын тоо	79	69	71	50	269
Хэрэгжилтийн хувь	98.6%	98.2%	97.5%	91%	96.3%

Хүснэгтээс харахад: 2017-2019 он, 2020 оны эхний хагас жилийн хугацаанд батлагдсан 269 тогтоолын хэрэгжилт 100%-тай 209, 70%-тай 9, 30%-тай 6, хугацаа болоогүй 45 буюу дундаж хэрэгжилт 96.3%-тай байна.

Бүрэн хэрэгжээгүй тогтоолын дийлэнх нь тайлант оны үйл ажиллагааны чиглэл батлах, ажил сайжруулах, аялал жуулчлал, уул уурхай, ан агнуур, эд хөрөнгө бүртгэх, зөвшөөрөл олгох, ном бүтээхтэй холбоотой тогтоолууд эзэлж байна.

Аудитаар тогтоолын биелэлтийн байдалд тулгалт хийсэн бөгөөд хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 5/

Хэрэгжилт	2019 он		2020 оны эхний хагас жил	
	Тайлагнасан	Тулгасан	Тайлагнасан	Тулгасан
100%	54	54	30	31
70%			7	7
30%	2		2	1
0%		2		
Хугацаа болоогүй	15	15	11	11
Нийт тогтоолын тоо	71	71	50	50
Хэрэгжилтийн хувь	97.5%	96.4%	91.02%	92.8%

Аудитын явцад хийсэн тулган баталгаажуулалтаар 2019 оны 30%-тай 2 тогтоолын үнэлгээг 0%-тай гэж үнэлэн биелэлтийн хувийг 97.5%-иас 96.4% болгон бууруулж, 2020 оны 70%-тай 1 тогтоолын хэрэгжилтийг 100%-тай гэж үнэлэн үнэлгээг 91.02%-иас 92.8% болгон нэмэгдүүллээ.

Тогтоолын хэрэгжилтийн тайланд өмнөх оноос хэрэгжилт дутуу буюу хангалтгүй хэрэгжсэн тогтоолын биелэлтийг оруулж тайлагнахгүй байна. Тус байгууллагын “Хууль эрх зүй, хяналт, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн”-ий албан тушаалын тодорхойлолтод тогтоолын хэрэгжилтийг хангах, тайлан гаргах талаар тусгасан боловч уг албан тушаалд ажиллах боловсон хүчин байхгүй байгаа нь дээрх алдаа, зөрчлүүд гарахад нөлөөлсөн байна.

2.1.2 Аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтэд тавих хяналт хангалтгүй, хэрэгжилтийг тухай бүр холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнаагүй байна.

Захирамжийн биелэлтийг аймгийн ЗДТГ-ын дотоод зохион байгуулалтын хүрээнд АЗДТГ-ын дарга жил бүр тайлан мэдээ гаргаж тайлагнах хуваарийг баталдаг бөгөөд уг хуваарьт ХЭЗХ-ийн бичиг хэргийн ажилтан нэгтгэж, тус хэлтсийн мэргэжилтэн, дарга нар хянах, ХШҮДАХ нь хэрэгжилтийг үнэлэх үүрэг хүлээсэн байна.

Дээрх хуваарийн дагуу 2018, 2019 оны аймгийн ЗД-ын захирамжийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс нэгтгэн дүгнэж, Дотоод аудит, хяналт шинжилгээ-үнэлгээний хэлтэст хүргүүлэн үнэлгээ хийлгэж дүгнүүлсэн байна. Тухайлбал: Дотоод аудит, хяналт шинжилгээ-үнэлгээний хэлтсээс аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтэд үнэлгээ хийж 2017 онд 98.1%, 2018 онд 98.2%-тай дүгнэжээ.

Харин Хууль, эрх зүйн хэлтсээс 2019 оны хэрэгжилтийг нэгтгэж хүргүүлээгүйн улмаас Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс хяналт, үнэлгээ хийгээгүй бөгөөд 2020 оны эхний хагас жилийн байдлаарх шийдвэрийн хэрэгжилтийг тооцож гаргаагүй байсныг аудитын явцад гаргуулан авсан.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.6.а дахь заалтын дагуу аймгийн Засаг даргын нийтлэг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

2017-2019 он, 2020 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн Засаг даргын нийт 1595 захирамжийн хэрэгжилтийг тайлагнасан байдлаар нь он тус бүрээр харуулбал:

/Хүснэгт 6/

Хэрэгжилт	2017	2018	2019	2020 оны эхний хагас жил	Дүн
100	424	465	455	143	1487
70	8	5	11	19	43
30	3	3	1	34	41
0		1		2	3
Хугацаа болоогүй	1	1	2	6	10
Үнэлэх боломжгүй		7	4		11
Захирамжийн тоо	436	482	473	204	1595
Хэрэгжилтийн хувь	98.7%	98.2%	99.1%	84.1%	94.1%

Хүснэгтээс харахад: 2017-2019 он, 2020 оны эхний хагас жилийн захирамжийн хэрэгжилт дунджаар 100%-тай 1487, 70%-тай 43, 30%-тай 41, огт хэрэгжээгүй 3, хугацаа болоогүй 10, үнэлэх боломжгүй 11 захирамж байна.

Бүрэн хэрэгжээгүй захирамжийн дийлэнх нь хөтөлбөр төсвийн задаргаа, газар эзэмшүүлэх, ажлын хэсэг томилох, гамшиг эрсдэл, журам батлах, төсөв санхүүтэй холбоотой захирамжууд эзэлж байна.

Захирамжийн биелэлтийг дунджаар авч үзэхэд 97.1%-тай буюу хангалттай биелсэн гэж тайлагнажээ.

Аудитаар захирамжийн биелэлтийн байдалд тулгалт хийсэн бөгөөд хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 7/

Хэрэгжилт	2019		2020 оны эхний хагас	
	Тайлагнасан	Тулгасан	Тайлагнасан	Тулгасан
100	455	453	143	143
70	11	10	19	19
30	1	1	34	33
0		6	2	5
Хугацаа болоогүй	2	3	6	4
Үнэлэх боломжгүй	4			
Захирамжийн тоо	473	473	204	204
Хэрэгжилтийн хувь	99.1%	97.9%	84.1%	83.1%

Аудитын явцад хийсэн тулган баталгаажуулалтаар 2019 оны 100%-тай 2, 70%-тай 1, хугацаа болоогүй-1, үнэлэх боломжгүй 4, нийт 8 захирамжийн үнэлгээг бууруулж, биелэлтийг 99.1%-иас 97.9%, 2020 оны 30%-тай 1, хугацаа болоогүй 6, нийт 7 захирамжийн үнэлгээг бууруулж, 84.1%-иас 83.1% болгон тус тус буурууллаа.

Захирамжийн хэрэгжилтийг ХЭЗХ-ийн бичиг хэргийн ажилтан нэгтгэж, тус хэлтсийн “Эрх зүйн сургалт, сурталчилгаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого хариуцсан мэргэжилтэн”, “Хууль, эрхзүйн хэлтсийн дарга” нар тус тус хянах үүргийг албан тушаалын тодорхойлолтод заасан байна.

2019 оны захирамжийн биелэлтийг ХЭЗХ-ээс нэгтгэн ирүүлэхдээ илтэд алдаатай болон дутуу мэдээлэл ирүүлснээс үзэхэд тайлан гаргалтын байдалд хяналт тавьдаггүй, ач холбогдол өгдөггүй, хайнга байгаа нь харагдаж байна. Тухайлбал:

1. Аймгийн Засаг даргын 2019 оны А/92 тоот захирамжаар “Нэгдсэн эмнэлгийн газардуулга, генераторын барилгын ажлын үнэлгээний хороо”-г байгуулсан боловч биелэлтийг хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэгч сонгон шалгаруулсан байдлаар тайлагнасан.
2. Аймгийн Засаг даргын 2019 оны А/93 тоот захирамжаар “Орон сууцны гадна шугам сүлжээний ажлын үнэлгээний хороо”-г байгуулсан боловч биелэлтийг хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэгч сонгон шалгаруулсан байдлаар тайлагнасан.

3. Аймгийн Засаг даргын 2019 оны А/227 тоот захирамжаар Шүдний эмнэлэгт тусгай зөвшөөрөл олгох захирамжийн биелэлтийг гражийн газар олголтоор тайлагнасан.
4. Аймгийн Засаг даргын 2019 оны А/47, А/64, А/71, А/73, А/211 дугаар захирамжуудын биелэлтийг жилийн эцсийн байдлаар буюу 2019 оны 12 сарын 31-ний байдлаар тооцож гаргаагүй.

Дээрх зөрчлөөс харахад захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх үүргээ ажил хариуцсан ажилтнууд хангалттай биелүүлээгүй байна.

Иймд аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтийг нэгтгэн гаргахдаа бодит тоо мэдээнд тулгуурлах, нэгтгэл хийж байгаа ажилтан болон хэлтэс бүр дотоод хяналтыг хэрэгжүүлж хяналт шалгалт хийх, төлөвлөгөө гарган ажиллах, хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн гүйцэтгэх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.1.3 Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамжийн биелэлтийн тайланг нэгтгэн гаргаж, дүн шинжилгээ хийж эрх бүхий этгээдэд тайлагнаагүй байна.

Аймгийн ИТХ нь Засаг даргад хариуцуулсан тогтоолын хэрэгжилтийг улирал бүр аймгийн ЗДТГ-аас хүлээн авч аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд тайлагнаж байна.

Бусад тогтоолын хэрэгжилтийг нэгтгэх, дүн шинжилгээ хийх ажлууд хийгдээгүй нь АИТХ-ын ажлын албаны “Хууль эрх зүй, хяналт, хүний нөөц” хариуцсан ахлах мэргэжилтний орон тоонд ажиллах боловсон хүчин томилогдоогүй байгаатай холбоотой байна.

Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн төлөвлөгөөнд “аймгийн Засаг даргаас гаргаж буй шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг сайжруулах, хяналт тавих, мэдээлэл зөвлөгөөгөөр хангана” гэж тусгасан боловч захирамжийн эрх зүйн үндэслэлийг хангалттай хянаагүй, дүн шинжилгээ хийгээгүйгээс зөрчилтэй захирамжийн тоо буураагүй байна.

Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүдийн албан тушаалын тодорхойлолтод аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтийг нэгтгэн гаргах үүргийг тусгасан боловч захирамжийн биелэлтэд дүн шинжилгээ хийж аймгийн Засаг даргад тайлагнаагүй байна.

2.1.4 Хэлтсүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулснаар дотоод хяналт үр дүнтэй хэрэгжих боломжтой байна.

Аймгийн ИТХ-ын даргын 2020 он А/26-р захирамжаар байгууллагын дотоод хяналтын журмыг баталжээ. Уг журам болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд дотоод хяналтыг “Хууль эрх зүй, хяналт, хүний нөөц” хариуцсан ахлах мэргэжилтэн гүйцэтгэхээр заасан боловч орон тоо дутуу ажиллаж байгаагаас шалтгаалан байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

Аймгийн Засаг даргын захирамжийн хувьд Хууль, эрх зүйн хэлтсийн “Эрх зүйн сургалт, сурталчилгаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого хариуцсан мэргэжилтэн”-ий албан тушаалын тодорхойлолтод “Аймаг, сумын Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаалын хууль, эрх зүйн үндэслэлийг хянах, нутгийн захиргааны байгууллагаас гаргаж буй захиргааны шийдвэр, эрх зүйн бусад баримт бичгийн боловсруулалтад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх” гэж захирамжийн хууль эрх зүйн үндэслэлд тус хэлтсээс тавих дотоод хяналтын чиг үүргийг тусгасан боловч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхой бус, зөрчилтэй эрх зүйн актын тоо буураагүй, жил бүр хууль эрх зүйн зөрчилтэй захирамж батлагдан гарсаар байна. Тухайлбал: 2017-2019 он, 2020 оны эхний хагас жилийн байдлаар 117 буюу нийт батлагдсан захирамжийн 3.8%-4.9% нь хууль эрх зүйн хувьд алдаатай батлагджээ.

Энэ нь захирамжийн төлөвлөлт, боловсруулалтын байдалд тавьж буй дотоод хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Хууль эрх зүйн хэлтсийн 2017-2019 он, 2020 оны эхний хагас жилийн ажлын тайланг авч үзэхэд аймгийн Засаг даргын захирамжийн төлөвлөлт, боловсруулалт, хэрэгжилтийн байдалд

хийх дотоод хяналтын төлөвлөгөө, гүйцэтгэлийн баримтгүй байна. Энэ нь алдаа, зөрчил давтагдан гарахад нөлөөлсөн байна.

Харин ДАХШҮХ нь АЗДТГ-ын дотоод хяналтыг хэрэгжүүлдэг бөгөөд 2017-2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 3 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Захирамжийн биелэлтэд хийсэн дотоод хяналтаар биелэлтийг 2017 онд 98.7%, 2018 онд 98.2% гэж үнэлсэн бол 2019 он, 2020 оны эхний хагас жилийн захирамжийн хэрэгжилтэд дотоод хяналт хийгдээгүй байсан ба аудитын явцад 2020 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн байдалд хяналтыг хийж, баримтыг нөхөн гаргаж ирүүлсэн байна. Энэ нь Хууль эрх зүйн хэлтсээс 2019 он, 2020 оны эхний хагас жилийн биелэлтийг батлагдсан хуваарийн дагуу тухай бүрд нь нэгтгэн ХШҮДАХ-т хүргүүлээгүйтэй холбоотой байна.

Аймгийн Засаг даргын захирамжийн төсөл болон хэрэгжилтэд хийгдэж буй дотоод хяналт хангалтгүй, хэлтсүүдийн ажлын уялдаа холбоогүй байдал нь аймгийн Засаг даргаас эрхзүйн зөрчилгүй шийдвэр гаргах, гаргасан шийдвэр нь үр дүнтэй хэрэгжихэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Цаашид Засгийн газрын 2011 оны 311-р тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” болон албан тушаалын тодорхойлолтод заасан дотоод хяналтыг хэрэгжүүлэх, гаргасан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

Аудитаар нийт 8 зөрчил илэрсэн ба зөрчлийг арилгуулах 8 зөвлөмж хүргүүлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

1. Хууль эрх зүйн үйлчлэл үзүүлэхгүй байх үр дагавартай захиргааны актуудыг батлан гаргасан байна.
2. АИТХ, Тэргүүлэгчдийн тогтоолуудын үндэслэлийн 1.3-18.0 хувь, аймгийн Засаг даргын захирамжийн үндэслэлийн 3.8-4.9 хувь нь холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудтай бүрэн нийцээгүй байна.
3. АИТХ-ын тогтоолын агуулга нь үндэслэл болгосон хууль тогтоомжтойгоо нийцсэн бол аймгийн Засаг даргын захирамжийн агуулгын 1.4-3.4 хувь нь үндэслэл болгосон хууль тогтоомжтойгоо бүрэн нийцээгүй байна.
4. АИТХ, Засаг даргаас батлан гаргаж буй шийдвэрийн дийлэнх хувь нийгмийн салбарт чиглэгдсэн байна.

Бүлэг-2

1. Аймгийн ИТХ-ын тогтоол болон Засаг даргын захирамжийн биелэлтийн байдалд дотоод тавих хяналт хангалтгүй, хэрэгжилтийг тухай бүр тайлагнаагүй байна.
2. Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамжийн биелэлтийн тайланг нэгтгэн гаргаж, дүн шинжилгээ хийж эрх бүхий этгээдэд тайлагнаагүй байна.
3. Эрх зүйн актуудын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулан, хэрэгжилтийг тухай бүр тооцож, хэлтсүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулснаар дотоод хяналт үр дүнтэй хэрэгжих боломжтой байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.
Үүнд:

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргад:

1. Захиргааны хэм хэмжээ тогтоож буй актуудыг Захиргааны хуульд заасны дагуу бүртгүүлж, захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд хэвлүүлэх
2. Тогтоолын төлөвлөлт, боловсруулалтад тавих хяналтыг сайжруулах, хуульд нийцсэн захиргааны акт гаргах
3. Засаг даргаас бусад албан тушаалтанд үүрэг болгосон тогтоолуудад тусгайлан хяналт тавьж, биелэлтийг тухай бүр тооцож, дүн шинжилгээ хийх
4. Дотоод хяналт хэрэгжүүлэх албан тушаалтныг томилж, батлагдсан журмын дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлэх

Аймгийн Засаг даргад:

1. Захиргааны хэм хэмжээ тогтоож буй актуудыг хуулийн дагуу бүртгүүлж, захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд хэвлүүлэх
2. Эрх зүйн актын хууль тогтоомжийн үндэслэлд хяналт тавих, холбогдох хууль, тогтоомжид заасан хүчин төгөлдөр заалтуудыг үндэслэн шийдвэр гаргах
3. Захирамжийн биелэлтийг нэгтгэн гаргахдаа бодит тоо мэдээнд тулгуурласан эсэхэд хяналт тавих, биелэлтийн байдалд дүн шинжилгээ хийх
4. Хэлтсүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулж, захирамжийн хэрэгжилтэд батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу дотоод хяналт хийх

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Утас: 7054 3225, Факс: (976) 7054 3271,
И-мэйл: govsumber_khural@yahoo.com,
Вэбсайт: www.govsumber.khural.mn

2020.10.23 № 158

тэнгэй 2020.10.20-ны № 292 -Т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын болон Тэргүүлэгчдийн хурлын тогтоол,
шийдвэрийн үндэслэл, түүний хэрэгжилтэнд
хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцаж,
холбогдох тайлбарыг хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА



Г.БАТЗАМ

В. Доржамбааг
Майрагтай,
таацагч,
малалт өрхөн
гаргах
2/20

№	Огноо	Дугаар	Агуулга	Салбар	Аудитын Тайлбар	Хариу тайлбар
Аймгийн ИТХТэргүүлэгчдийн тогтоол						
1	2017.12.19	56	Зардал гаргах тухай	Төсөв санхүү	МУЗЗНДНТ УТХ-ийн 25.1 Тогтоол гаргах эрх бөгөөд тухайн арга хэмжээтэй хамааралгүй заалт	- Тус зардыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Хурлын нөөц сангийн журам батлах тухай" 48 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу нөөц сангаас зарцуулсан. Тус журмын 2.1 дэх заалтанд "... 1000000 төгрөгийн асуудлыг Хурлын даргын захирамжаар, 1000001 буюу түүнээс дээш төгрөгийн асуудлыг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор баталгаажуулна." гэж заасан байдаг. Уг зардал нь 1000000 төгрөгөөс дээш дүнтэй учир журмын дагуу Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцсэн. - МУЗЗНДНТУТХ-ийн 25.1 "Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд түүнийг тухайн Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн болон баг, хорооны Хурлын хуралдаанд оролцсон иргэдийн олонхийн саналаар тус тус батална" гэж заасны дагуу зардал гаргах асуудлыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлцэж шийдвэр гаргасан бөгөөд тогтоол гаргах заалтыг зайлшгүй авах шаардлагатай учир уг заалтыг үндэслэсэн. - Тус зардлыг гаргахдаа аймгийн ИТХ-ын даргын нөөц санг зарцуулах журмын 2.2.2 дахь заалтыг тогтоолын үндэслэл хэсэгт тусган, уг заалтын хүрээнд нөөц сангаас гаргасан болно.
2	2018.02.06	3	Цагаан сарын барилдаан зохион байгуулах зардал гаргах тухай	Тэмцээн уралдаан	МУЗЗНДНТ УТХ-ийн 25.1 Тогтоол гаргах эрх бөгөөд бөхийн барилдаан зохион байгуулах хуулийн заалт байхгүй	- Тус зардыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Хурлын нөөц сангийн журам батлах тухай" 48 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу нөөц сангаас зарцуулсан. Тус журмын 2.1 дэх заалтанд "... 1000000 төгрөгийн асуудлыг Хурлын даргын захирамжаар, 1000001 буюу түүнээс дээш төгрөгийн асуудлыг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор баталгаажуулна." гэж заасан байдаг. Уг зардал нь 1000000 төгрөгөөс дээш дүнтэй учир журмын дагуу Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцсэн. - МУЗЗНДНТУТХ-ийн 25.1 "Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд түүнийг тухайн Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн болон баг, хорооны Хурлын хуралдаанд оролцсон иргэдийн олонхийн саналаар тус тус батална" гэж заасны дагуу зардал гаргах асуудлыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлцэж шийдвэр гаргасан бөгөөд тогтоол гаргах заалтыг зайлшгүй авах шаардлагатай учир уг заалтыг үндэслэсэн. - Тус зардал нь 1000000 төгрөгөөс дээш дүнтэй учир аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Хурлын нөөц сангийн журам батлах тухай" 48 дугаар тогтоолоор батлагдсан журмын 2.1 дэх заалтын дагуу "Цагаан сарын барилдаан зохион

					байгуулах зардал гаргах тухай" асуудлыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн. - Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заагдсаны дагуу тэмдэглэлт өдрийг тохиолдуулан Цагаан сарын барилдаан зохион байгуулах зардлыг гаргахдаа аймгийн ИТХ-ын даргын нөөц санг зарцуулах журмын 2.4, 2.7 дахь заалтыг тогтоолын үндэслэл хэсэгт тусган, уг заалтын хүрээнд нөөц сангаас гаргасан болно.
3	2019.01.22	2	Үндэсний бөхийн барилдаан зохион байгуулах тухай	Тэмцээн уралдаан	МУЗЗНДНТУТХ-ийн 25.1 Тогтоол гаргах эрх бөгөөд бөхийн барилдаан зохион байгуулах хуулийн заал байхгүй - Тус зардыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Хурлын нөөц сангийн журам батлах тухай" 48 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу нөөц сангаас зарцуулсан. Тус журмын 2.1 дэх заалтанд "... 1000000 төгрөгийн асуудлыг Хурлын даргын захирамжаар, 1000001 буюу түүнээс дээш төгрөгийн асуудлыг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор баталгаажуулна." гэж заасан байдаг. Уг зардал нь 1000000 төгрөгөөс дээш дүнтэй учир журмын дагуу Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцсэн. - МУЗЗНДНТУТХ-ийн 25.1 "Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд түүнийг тухайн Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн болон баг, хорооны Хурлын хуралдаанд оролцсон иргэдийн олонхийн саналаар тус тус батална" гэж заасан байдаг. Иймд зардал гаргах асуудлыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлцэж шийдвэр гаргасан бөгөөд тогтоол гаргах заалтыг зайлшгүй авах шаардлагатай учир уг заалтыг үндэслэсэн. - Тус зардал нь 1000000 төгрөгөөс дээш дүнтэй учир аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Хурлын нөөц сангийн журам батлах тухай" 48 дугаар тогтоолоор батлагдсан журмын 2.1 дэх заалтын дагуу "Цагаан сарын барилдаан зохион байгуулах зардал гаргах тухай" асуудлыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заагдсаны дагуу тэмдэглэлт өдрийг тохиолдуулан Цагаан сарын барилдаан зохион байгуулах зардлыг гаргахдаа аймгийн ИТХ-ын даргын нөөц санг зарцуулах журмын 2.4, 2.7 дахь заалтыг тогтоолын үндэслэл хэсэгт тусган, уг заалтын хүрээнд нөөц сангаас гаргасан болно.
4	2019.01.22	3	АИТХТ-ийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах	Ажлын төлөвлөгөө батлах	МУЗЗНДНТУТХ-ийн 25.1 Тогтоол гаргах эрх бөгөөд бөхийн - МУЗЗНДНТУТХ-ийн 25.1 "Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд түүнийг тухайн Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн болон баг, хорооны Хурлын хуралдаанд оролцсон иргэдийн олонхийн саналаар тус тус батална" гэж заасан байдаг. - АИТХТ-ийн 2019 оны гүйцэтгэлийн

					барилдаан зохион байгуулах хуулийн заалт байхгүй	төлөвлөгөө батлах тухай асуудлыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж шийдвэр гаргасан бөгөөд тогтоол гаргах заалтыг зайлшгүй авах шаардлагатай учир уг заалтыг үндэслэсэн. 20.5. Хурлын Тэргүүлэгчид үйл ажиллагаагаа тухайн Хуралд жилд 1-гээс доошгүй удаа тайлагнана гэсний дагуу тэргүүлэгчдийн үйл ажиллагааны төлөвлөгөө жил бүр тэргүүлэгчдийнхээ хурлаараа хэлэлцэж баталдаг.
5	2019.03.12	6	Барьцаа хөрөнгө чөлөөлөх	Үндсэн хөрөнгө	ТБОНӨТХ-ын өмч барьцаалах заалт нь 77.3 заалт байхад 77.2 буюу хамааралгүй заалтыг үндэслэж шийдвэр гаргасан.	- ТБОНӨТХ-ын 77 дугаар зүйлийн 77.3-т Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ гэсний дагуу хөрөнгө барьцаалахдаа энэ заалтыг барьсан. - ТБОНӨТХ-ын 77 дугаар зүйлийн 77.3-т барьцаа хөрөнгийг чөлөөлөхтэй холбоотой утга байхгүй учир барьцаалсан хөрөнгөө барьцаанаас нь чөлөөлөхдөө буцаагаад эзэмшүүлэх гэдэг утгаар нь ТБОНӨТХ-ын 77 дугаар зүйлийн 77.2 "Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхтээ..." гэсэн заалтыг тогтоолд үндэслэсэн болно.
6	2019.05.30	17	ОНӨХуулийн этгээдийн газар эзэмших эрх, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний дүнг батлах	Үндсэн хөрөнгө	ТБОНӨТХ-н өмч 25.2, 25.4 дэх заалтууд АИТХ-ыг бүрэн эрхэд хамааралгүй.	Тус заалтыг Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн Х.Алтанцэцэг тухайн үед энэ заалтыг заавал авах шаардлагатай дахин үнэлгээтэй холбоотой энэнээс өөр заалт байхгүй гэж тайлбарласан учир авсан болно. Цаашид аймгийн ЗДТГ-ын хэлтэс, агентлагуудаас хуралд оруулж танилцуулан шийдвэрлүүлж буй асуудлуудын хууль, эрх зүйн үндэслэлд хяналт тавих ажлыг сайжруулж ажиллах болно.
7	2019.07.23	26	Аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр шагнах	Шагнал урамшуулал	ТТХ-ийн 14.2.3-дахь заалт ТЕЗ-ийн бүрэн эрхэд хамаарна.	Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл.Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх 14.1.Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна: 14.1.15 аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн; 14.2.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах; ... гэж хуулинд заасан тул төсвийг гаргахдаа уг заалтыг тогтоолд үндэслэсэн болно.
8	2019.07.23	27	Зардал гаргах	Хөрөнгө зарцуулах	ТТХ-ийн 14.2.3-дахь заалт ТЕЗ-ийн бүрэн эрхэд хамаарна.	Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл.Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх 14.1.Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна: 14.1.15 аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн; 14.2.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн

					удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах; ... гэж хуулинд заасан тул төсвийг гаргахдаа уг заалтыг тогтоолд үндэслэсэн болно.
9	2019.09.24	28	Хөрөнгө худалдах зөвшөөрөл олгох	Хөрөнгө зарцуулах	МУЗЗНДНТУ-ийн 20.1.8-д дахь заалт нь төрийн дээд шагналд тодорхой-лох заалт бөгөөд үүнийг үндэслэж шийдвэр гаргасан. Бичиг хэргийн ажилтан тогтоол гаргахдаа өмнөх хуулийн заалтаа хуулбарлаж засвар хийхдээ МУЗЗНДНТУ-ийн 20.1.8-д дахь заалт буюу төрийн дээд шагналд тодорхойлох заалтаа устгалгүй гаргасан байна. Цаашид эцэслэгдэн гарч буй тогтоолуудыг үндэслэлийн хяналтыг сайжруулж ажиллах болно.
10	2019.10.21	32	МУГД Л.Цэдэнсодном агсны нэрэмжит волейболын тэмцээн	Тэмцээн уралдаан	Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх 14.1. Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна: 14.1.15 аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн; 14.2. Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.3. өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах; ... гэж хуулинд заасан тул төсвийг гаргахдаа уг заалтыг тогтоолд үндэслэсэн болно.
11	2019.11.12	41	Журам батлах тухай тогтоолын хавсралтанд нэмэлт оруулах	Журам батлах	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 05 дугаар тогтоолоор "Дэлхий, тив, улсын зэрэглэлтэй тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах журам"-ыг баталсан. Уг журмын 2 дугаар хавсралтанд нэмэлт оруулах санал аймгийн ЗДТГ-аас ирсэн бөгөөд уг асуудлыг тайлбарлахдаа хариуцсан мэргэжилтэн Ц.Сүхбаатар нь тамирчин тэмцээн наадамд оролцох гэдэг утгаар нь тэмцээн наадамд оролцоод амжилт үзүүлвэл ийм ийм урамшуулал олгоно гэж оруулж байгаа гэж тайлбарлан уг заалтыг үндэслэнэ гэсэн учир авсан болно. Цаашид аймгийн ЗДТГ-ын хэлтэс, агентлагуудаас хуралд оруулж танилцуулан шийдвэрлүүлж буй асуудлуудын хууль, эрх зүйн үндэслэлд хяналт тавих ажлыг сайжруулж ажиллах болно.
12	2019.12.13	51	Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам батлах	Журам батлах	ТБОНӨТХ-н 11.1, 11.2 заалтууд нь төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх бөгөөд нутгийн өөрөө ТБОНӨТХ-н 11.1, 11.2 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараах бүрэн эрхтэй: 1/төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах; 2/ төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж,

					удирдах байгууллагад хамааралгүй.	түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах; /ОНӨ-ийн газар/ ТБОНӨТХ-н 77 дугаар зүйл. Орон нутгийн өмчийн талаархи иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн ээрх МУЗЗНДНТУТХ-ийн 20 дугаар зүйл. Хурлын Тэргүүлэгчдийн бүрэн эрх
13	2019.12.13	53	Тэргүүлэгч дэд урамшуулал олгох тухай	Шагнал урамшуулал	ТТХ-ийн 14.2.3-дахь заалт ТЭЗ-ийн бүрэн эрхэд хамаарна.	Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл.Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх 14.1 Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна: 14.1.15 аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн; 14.2.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах; ... гэж хуулинд заасан тул төсвийг гаргахдаа уг заалтыг тогтоолд үндэслэсэн болно.
Аймгийн ИТХ-ын тогтоол						
14	2019.11.29	3	Газар эзэмших эрхийг шилжүүлэх зөвшөөрөл олгох	Газар эзэмшүүлэх	ТБОНӨТХ-н 9.1, 9.2 заалтууд нь Төрийн өмчийн талаарх засгийн газрын бүрэн эрхэд хамаарна.	ТБОНӨТХ-н 9.1, 9.2 дахь заалтыг Засгийн газар үндэслэн 2013 онд 38 дугаар тогтоолыг гаргасан. Уг тогтоолын 6 дахь хэсгийг үндэслэн эрх шилжүүлэх тогтоол гарах байсан бөгөөд тогтоолын төслөө ГХБХБГ-аас ирүүлэхдээ ТБОНӨТХ-н 9.1, 9.2 дахь заалтыг барьж ирүүлсэнг нягталж шалгалгүй гаргасан байна. иймд цаашид дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч аймгийн ЗДТГ-ын хэлтэс, агентлагуудаас хуралд оруулж танилцуулан шийдвэрлүүлж буй асуудлуудын хууль, эрх зүйн үндэслэлд хяналт тавих ажлыг сайжруулж ажиллах болно.
15	2019.11.29	5	Аймгийн боловсролын байгууллагуудын 2019 оны төсөвт зохицуулалт хийх	Төсөв санхүү	ТТХ-н 41.2.2, 42.2.1 ТЭЗ-ийн бүрэн эрхийг үндэслэл болгосон.	Аймгийн ЗДТГ-аас уг асуудлыг шийдвэрлүүлэхдээ авах ёстой заалт гэж тайлбарлан тогтоолын үндэслэл хэсэгт авсан. Уг заалтыг тус байгууллагаар тайлбар гаргуулж авсан. /Тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна./

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор захиргааны хэмж хэмжээ тогтоосон актын тайлбар

№	он	Дугаар	Тайлбар
1	2017	22	- 2017 оны 02 дугаар сарын 14-нд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 86 дугаар тогтоолоор орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлагдсан. Уг журмыг орон нутгийнхний үйл ажиллагаанд нийцүүлэн батлуулахыг Орон нутгийн өмчийн газарт өгсний дагуу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцэж 22 дугаар тогтоолоор "Орон нутгийн өмчид эд хөрөнгө орлж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг баталсан. - Төрийн захиргааны төв байгууллагат жижиг журам гарч түүнээс орон нутагууд орон нутгийнхаа хүрээнд журмаа баталж мөрдөж ажиллаж байсан. Засгийн газар жил бүрийн эхэнд орон нутгийн удирдлагуудтай уулзалт хийдэг бөгөөд тус уулзалтаар Хууль зүйн сайд орон нутагтынхаа хүрээнд хэрэгжүүлэхээр баталсан журмыг бүртгүүлэхээр ирүүлэх шаардлагагүй гэсэн чиглэлийг өгсөн.
			- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны "Журам батлах тухай" 86 дугаар тогтоол нь дахин шинэчлэгдэхээр болж 2020 онд хүчингүй болсон тул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн "Орон нутгийн өмчид эд хөрөнгө орлж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг 22 дугаар тогтоолыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор хүчингүй болгоод байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

Аймгийн ИТХ-аас ирүүлсэн саналтай танилцаад дараах тайлбарыг өгч байна.

Тайлбар 1:

Нийцлийн аудитын тайлангийн хавсралт 2-т зөрчилтэй гэж тусгагдсан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 26, 27,32, 53, аймгийн ИТХ-ын 2019 оны 5-р тогтоолуудад ирүүлсэн тайлбарыг хууль, эрх зүйн хувьд үндэслэлтэй гэж үзсэн тул жагсаалтаас хасаж аудитын тайланд дараах өөрчлөлтийг оруулав.

1.1.1 “Аудитаар АИТХ-ын Тэргүүлэгч болон АИТХ-ын тогтоолын үндэслэлүүд нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжтой нийцэж буй эсэхийг шалгахад 2020 оны эхний хагас жилд батлагдсан 50 тогтоолын үндэслэл хуульд нийцэж байсан ба 2017 оны 79 тогтоолын 1 буюу 1.3 хувь, 2018 оны 69 тогтоолын 1 буюу 1.4 хувь, 2019 оны 71 тогтоолын 8 буюу 11.2 хувь нь эрхзүйн хангалттай үндэслэлгүй буюу хуульд бүрэн нийцээгүй байна.

Тайлбар 2:

Эрх зүйн хэм, хэмжээ тогтоож байгаа актыг бүртгүүлэх асуудлыг Захиргааны ерөнхий хуульд тодорхой заасан. Тус байгууллагаас “Орон нутгийн хүрээнд хэрэгжүүлэхээр баталсан журмыг бүртгүүлэх шаардлагагүй гэж чиглэл өгсөн” гэж тайлбар ирүүлсэн нь хууль эрх зүйн хувьд үндэслэлгүй байна.

Тус захиргааны хэм хэмжээ тогтоож байгаа акт нь 2020 онд хүчингүй болсон боловч цаашид захиргааны хэм хэмжээ тогтоож буй актыг тухай бүр бүртгүүлэхийг зөвлөмжөөр хүргүүлсэн тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.